



Өдөр -12
Шөнө -21

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

“ОЮУНЫ ЭЛЧ” БОЛОХ ОНЫ ШИЛДЭГ ЗАЛУУ БАГШ НАРЫГ ШАЛГАРУУЛЛАА

II нүүрт

ДЭЛХИЙ

Р.ЭРДОГАН ЭЛЧИН САЙДЫН ҮХЭЛД Ф.ГЮЛЛЕНЫГ СЭЖИГЛЭВ

IV нүүрт

Дугаарын **60** мөр

Төрийн албанд орж баяжихыг мөрөөдөгчид олширчээ

ч.чулуун

“Төрийн албанд орчихвол ч амьдрал аандаа сэргэнэ. Танд таньдаг хүн байна уу. Дүү нь гомдоохгүй шүү. Тендер дээр ажиллаад л арван хувийг нь халаасалчихдаг юм гэнэ лээ. Тиймээс аль болох аймаг нийслэл, сум дүүргийн газрын алба, үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс, татварын албанд ажилд ормоор байна. Төрийн албаны шалгалтыг аргалах хүн олж өгөөч. Мөнгийг нь өгнө өө” гэх залуучуудтай алхам тутамд тааралдах боллоо. Юуны учир залуучууд төрийн албан хаагч болохын төлөө ийн улайрна вэ. Учир бий болоод л тэр. Үнэндээ ч төрийн албанд толгойгоо шургуулж чадсан хэн хүний амьдрал нүдэн дээр илт сэргээд ирдгийг бид мэднэ.

Төгсгөл нь III нүүрт

ХЭН, ЮУ ХЭЛЭВ

З.Нарантуяа: Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгогдсон 2.5 их наядын зээлийг чанаргүй гэж үзэх нь утгагүй

/УИХ-ын гишүүн/

Хөгжлийн банктай холбоотой асуудал нэг байлаа. Өчигдөр УИХ-ын чуулганаар Хөгжлийн банктай холбоотой асуудлыг хэлэлцэх байсан ч хойшлуулчихсан. Тэгвэл энэ асуудлаар УИХ-ын гишүүн З.Нарантуяа ярилцлага өгч, цөөнгүй зүйлийг ярьжээ. Тэрбээр “Хөгжлийн банкны гаргасан зээлийн 70-90 хувь нь чанаргүй гэж дүгнэх нь буруу. Нэгдүгээрт, Засгийн газрын баталгаатай, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийн

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ХАТУУ ШИЙТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬТАЙ БОЛЛОО

Ж.ОТГОН

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан өчигдөр 52.6 хувийн ирцтэй эхэллээ. Хуралдааны эхэнд Засгийн газраас өргөн

хувьд өглөгөө Хөгжлийн банкнаас авах авлагадаа суутгуулан тооцох болж байна. Ингэхээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгогдсон 2.5 орчим их наядын зээлийг чанаргүй гэж үзэх нь утгагүй болсон. Хоёрдугаарт, арилжааны банкуудаар дамжуулж 1600 орчим төсөлд олгосон 800 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөгдөх эрсдлийг гэрээний дагуу арилжааны банкууд хүлээсэн. Банкууд зээлдэгчдээсээ авна, одоогоор төлбөр, тооцоогоо саадгүй хийж байгаа, харилцагчид нь асуудалгүй байгаа учраас эдгээр зээлүүдийг муудсан гэж үзэх нь утгагүй юм.

Үргэлжлэл нь III нүүрт



Манай сонины I улирлын захиалга явагдаж байна

Захиалгын үнэ

22400



Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ОНЦЛОХ МЭДЭЭ



Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат АНУ-аас Монгол Улсад Суугаа Элчин сайд Женнифер Зимдал Галттай Монгол-Америкийн зам, тээврийн салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцоо.

Уулзалтын эхэнд хоёр улс эрх тэгш, харилцан итгэлцсэн түншлэлийг хөгжүүлж ирсэн бөгөөд 30 жилийн хугацаанд

Дэд бүтцийн салбарт хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлэв

хамтын ажиллагаа тууштай өргөжин хөгжиж өнөөдөр иж бүрэн түншлэлийн хэмжээнд хүртэл хөгжиж байгааг сайд Д.Ганбат онцлов. Тэрээр хоёр улс хамтран Мянган сорилтын сангийн тусламжийн хөрөнгөөр Чойр-Сайншандыг холбосон 176.4 километр авто замыг барьсан нь зам, тээврийн салбарын хэмжээнд хэд хэдэн төслийг амжилттай хэрэгжүүлсний гэдгийг гэдгийг хэллээ. Мөн Дэд бүтэц хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүд болох шинэ төмөр зам, олон улсын шинэ нисэх буудал, дамжин өнгөрөх тээвэр, автозамын төсөл хөтөлбөрүүдээ танилцууллаа. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016-

2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд яамны зүгээс хийгдэх ажлуудаа Элчин сайдад танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр хэд хэдэн санал тавьсан юм. Тухайлбал Монгол Улс, АНУ-ын хооронд байгуулах МСС-ийн хоёр дахь Компакт гэрээнд зам, тээврийн салбарыг хамруулах боломжтой тохиолдолд тээврийн дэд бүтцийн салбарт хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв. Тухайлбал, Чойр-Сайншандын замыг гурван эгнээтэй болгон өргөтгөж хүчитгэх, Улаанбаатар-Налайх-Замын-Үүд чиглэлийн 620 км замыг зам дагуух үйлчилгээний

байгууламжийн хамт шинэчлэх, УБ-Дархан чиглэлийн замыг дөрвөн эгнээ бүхий нэгдүгээр зэргийн зам болгон бүрэн шинэчлэх саналыг тавьжээ. Мөн аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбох ажилд дутуу байгаа бөгөөд Говь-Алтай, Увс аймгийн чиглэлд тус бүр 130 км зам дутуу байгааг гүйцээж барих шаардлагатай байгааг дуулгалаа. Элчин сайд Женнифер Зимдал Галт Монгол Улсын эдийн засаг, нийгмийн чиглэлд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байгаа бөгөөд цаашид зам, тээврийн салбарт хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

Төгсгөл нь II нүүрт

100% Байгалийн цэвэр шүүс

Амьд байгалийн амт шимт
KAGOME

Шинэ жилийн урамшуулал
Хүргэлт үнэгүй

Хүргэлтийн утас: 99904283

Since 1899

5 Том + 1 Том

3 Том + 1 Жижиг

Нэмэлт сахар, амт оруулагч, үнэр, өнгө, нөөшлөгч агуулаагүй.

ХААН Банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2484.00	2494.00	ФУНТ	3015.00
ЕВРО	2545.00	2615.00	РУБЛЬ	38.80
ИЕН	20.90	21.22	ЮАНЬ	356.90

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

АН-ын даргын сонгуулийн сурталчилгаа Хэнтий аймгаас эхэллээ

АН-ын даргын сонгуульд нэр дэвшигчдийн сурталчилгаа очигдрөөс албан ёсоор эхэллээ. Сурталчилгааг их эзэн Чингис хааны өлгий Хэнтий аймгаас эхлүүлж, 40 хоногийн хугацаанд Монгол Улс даяар үргэлжлүүлэх юм.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ХАТУУ ШИЙТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬТАЙ БОЛЛОО

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Ц.Нямдорж дарга хауст амьдардаг болохоор мэдэхгүй байж магадгүй. Утааны асуудал хүнд байна” гэлээ. Түүний хариуд УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж “О.Баасанхүү хэлэлцэж байгаа асуудлаас өөр юм яриад байна. Өнөөдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг хэлэлцэж байна” гэдгийг сануулсан юм.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

хорооноос гаргаж УИХ-ын чуулганаар хэлэлцүүлээ. Ингээд хэлэлцүүлгийн шатанд байнгын хорооны горимын саналыг гишүүд дэмжиж, дээрх дөрвөн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл батлагдлаа.

сайд, Эрүүл мэндийн сайд нар хамтраад хуулийн нэмэлт өөрчлөлт хэлбэрээр асуудлаа Засгийн газарт оруулж ирж байгаа” гэв. Ийнхүү дээрх дөрвөн хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталлаа.

Ц.Нямдорж: Сулин хээрийн отрядын нутаг алттай гэж би анх удаа сонсч байна

Үүний дараа Монгол Улсын Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Хуралдааны явцад гишүүд асуулт асууж хариулт авсан юм.

цэцэрлэг сургууль байдаггүй учраас хүмүүс очдоггүй юм. Тиймээс хилийн цэргүүдэд арай өөр нөхцөл боломж олгож байж авч ажиллуулдаг. Сулин хээрийн отрядын тухайд хуучин байрлалыг орон нутгийн өмчид шилжүүлж өгөх хууль орон нутгийн удирдлагуудад тавьсан. Тэнд алт байвал орон нутаг өөрсдөө авна биз.

Гишүүд хардах эрхээр асуудал ярьж байна гэж сүүлийн найман жил ярих болсон. Хардлагад суурилсан дэл сул яриа их яваад байна. Хардах эрх бол жирийн иргэдэд байж болно.

цэрэг мөрөөрөө ажиллаж байхад хоёр хувааж, гурван жил тоглосон. Үүнээс үүдэж цэргийн байгууллагад ажиллаж буй хүмүүсийн ажилласна жил тасарсан нь 4 бий. Тэр тасарсан он жилийг яаж шийдэх юм бэ.

Ийнхүү үдээс хойшхи УИХ-ын чуулганаар Хилийн тухай хуулийн төсөлтэй холбоотой 60 орчим зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулсаар ажлын цаг дууссан юм.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Ж.МЯГМАР

“Yes! Mongolia” Монголын залуу багш нарын холбоо 21 аймаг, нийслэлийн боловсрол соёлын газруудтай хамтран “Оюуны элч-2016” оны шилдэг залуу багшийг шалгаруулах ёслолын ажиллагаа Төрийн ордны их танхимд боллоо.

...Монголын залуу багш нарын холбоо нийслэлийн есөн дүүрэг, 21 аймагт салбар зөвлөлтэй үндэсний хэмжээний томоохон байгууллага болон өргөжин хөгжөөд байна...



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

“ОЮУНЫ ЭЛЧ” БОЛОХ ОНЫ ШИЛДЭГ ЗАЛУУ БАГШ НАРЫГ ШАЛГАРУУЛЛАА

багш нарын холбоо боловсролын салбарыг дэмжиж, тэр тусмаа манай залуу шилдэг багш нарыг шалгаруулж байгаад баяртай байна. Энэ ёслолыг зохион байгуулж байгаад УИХ-ын эрхэм гишүүн Н.Учралд болон ивээн тэтгэж оролцож байгаа бүх хүмүүст БСШУСЯ-ны нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлж байна.

байгаа гэнэ. Харин эдгээр таван элч нь 2017 онд Монголын залуу багш нарыг төлөөлөх юм байна. Өөрөөр хэлбэл, эдгээр оюуны элчээрээ дамжуулан их, дээд сургуулиудынхаа оюутнууд болон багш нар цаашид нийгэмд оюун санааны өөрчлөлтийг хийхийг зорьж байгаа ажээ.

2015 онд үндэсний хэмжээний байгууллага болох зорилт дэвшүүлэн бүтэц бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулж, дэлхийн 150 багш орны 3500 байгууллага, 10 мянга гаруй гишүүд дэмжигчидтэй олон улсын багш нарын холбооны гишүүн Юнескод зөвлөх эрхтэй байгууллага болон өргөжүүлж ажилласан байна.

Багш нарт тулгамдаад байгаа эдгээр асуудлыг парламентад суудалтай болоод суудалгүй намуудын мөрийн хөтөлбөрт тусгасан байх ёстой гэдэг саналыг хүргүүлсэн юм.

холбооны “Оюуны од” цол тэмдэг, “Оюуны элч” цомын эздийг шалгарууллаа. Тодруулбал, “Оюуны элч” цомын эздээр Л.Тэмэнбаяр /ШУТИС-ийн Механик инженерийн сургууль/, С.Буяндэлгэр /Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 11 дүгээр сургууль/, Д.Сарантуяа /Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 139 дүгээр цэцэрлэг/, С.Батаа/Ховдаймгийнполитехник коллеж/, Б.Баасандорж /Монголын оюун ухааны академи/ нар тодорлоо.

MINFO. МОНГОЛЫН МЭДЭЭ 19 дэх жилдээ. Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО. Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ. Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ. Ахлах редактор: Б.ӨНӨРТӨГТОХ. Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД. Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТӨГТОХ. Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН. Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ. Маркетинг, зар сурталчлаланы алба: Н.АЛТАНЦЭЦЭГ. Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ. Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар. 209, 211 тоот. Харилцах утас, факс: 976-70113551.

СПОРТ

ЭЗЭН ХААНЫ ЦОМД "ГООЛЫН БОРОО" ОРЛОО

VI нүүрт

Э.БЭХБАЯР ЭНЭТХЭГИЙН "PRO WRESTLING LEAGUE SEASON 2" ТЭМЦЭЭНД УРИГДЖЭЭ

VII нүүрт



АМЖИЛТЫН ЭЗЭН

Мацүмото Каори: Д.СУМЪЯАГ ХЭТ БАРДСАНААС БОЛЖ ЯЛАГДСАН



Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Мацүмото Каори бол Японы шилдэг эмэгтэй тамирчдын нэг. Тэрбээр 2012 оны Лондонгийн олимпын эмэгтэй жүдо бөхийн 57 кг-ийн жинд зодоглон алтан медаль хүртэж, 2010, 2011 оны Дэлхийн АШТ-нд мөн л түрүүлж байв. Дэлхийн жүдо бөхийн спортын ертөнцөд "Чоно" гэх нэрээр алдаршсан тэрбээр энэ зуны Рио де Жанейрогийн олимпын наадмын хагас шигшээд манай тамирчин Д.Сумъяатай таарч, ялагдсан удаатай. Гэсэн ч, олимпын хүрэл медалиар энгэрээ мялаасан билээ. Тэгвэл алдарт тамирчны олимпын талаарх сэтгэгдэл хийгээд бага насны он жилүүд, цаашдын зорилгынхоо талаар орон нутгийн хэвлэлд хэрхэн ярьсныг орчуулан хүргэж байна.

Төгсгөл нь VII нүүрт


МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Оросын чөлөөт бөхийн дасгалжуулагч Монголын багийг онцолжээ

ОХУ-ын эмэгтэй чөлөөт бөхийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч Юрий Шахмурадов ирж байгаа шинэ онд тавьж байгаа зорилгуудын тухай ярилцлага өгчээ. Тэгэхдээ Монголын багийг онцолж, дэлхийн томчуудтай хамтатган ярьсан байна. Тэрбээр "Оросын спортын бөхийн холбоо, эмэгтэй үндэсний шигшээ багийн удирдлагын зүгээс эмэгтэй бөхчүүдийн бэлтгэл сургуулийн арга зүйг өөрчлөх шийдвэр гаргасан. Томоохон тэмцээнүүдэд дээгүүр давхиын

тулд бэлтгэл сургуулийг нухацтай хийж байх хэрэгтэй байна. Ирэх 2017 онд эмэгтэй чөлөөт бөхийн спорт өндөр хөгжсөн АНУ, БНХАУ, Канад, Монгол, Япон гэсэн стратегийн хувьд чухал таван оронд хамтарсан бэлтгэл сургуулилт, нөхөрсөг уулзалт-тэмцээн хийхээр төлөвлөөд байна. Энэ бол 2017 онд тавьж байгаа гол зорилго, тэгж байж л дэлхийд тэргүүлэгчдийн эгнээнд багтах болно. Ирж байгаа онд бид 13 чухал тэмцээний жагсаалт гаргаж тэдгээр тэмцээнд оролцсон байдлыг харгалзан эмэгтэй

бөхчүүдийн чансааг байнга гаргадаг болно. Наймдугаар сард Франц улсад болох ДАШТ-нд оролцох хүсэлтэй байгаа бөхчүүд 7-8 чухал тэмцээнд оролцсон байх ёстой. Маш хатуу өрсөлдөөний үр дүнд л бөхчүүдийн ур чадвар сайжирдаг, төгөлдөрждөг. Манай эмэгтэй бөхчүүд ирэх оны нэгдүгээр сарын сүүлчээр болох И.Ярыгиний нэрэмжит олон улсын тэмцээнээс 2017 оны шинэ улирлаа эхэлнэ" гэж онцлон өгүүлсэн байна.



Монгол дасгалжуулагчийн зургаар бүтсэн эможиг ухаалаг утсан дээрээ татаарай

Чөлөөт бөхийн хоёр дасгалжуулагч булхайтай шүүлтийн эсрэг тэмцэж, бухимдахдаа хувцсаа тайлж шидсэн үйлдэл гаргасан нь өнөөдрийг хүртэл дуулиантай сэдэв болсоор байгаа билээ. Энэ үйлдлээс болоод Дэлхийн бөхийн нэгдсэн холбооноос манай чөлөөтнийхний тэмцээнд оролцох эрхийг хасах дээрээ тулсан. Мөн Монголын Чөлөөт бөхийн холбооны зүгээс тэднийг илт буруутгаж, торгож, шийтгэсэн. Тэгвэл манай дасгалжуулагчийн уг үйлдэл олон улсын спортын хөгжөөн дэмжигчдийн дунд алдаршиж, дасгалжуулагчийн зургаар ухаалаг утасны эможиг зохион бүтээж хэрэглээнд нэвтрүүлжээ. Уг эможи нь iPhone, iPad дээр татах боломжтой бөгөөд app store-оос 0.99 ам.доллараар татаж аван ашиглах боломжтой юм байна.

Дэд хурандаа Б.Цэвээндаш "Алтан хараацай"-н эзэн боллоо

ШШПГЕГ-ын "Сүлд" биеийн тамир спортын хорооны Соёл олон нийт, биеийн тамирын асуудал хариуцсан ажилтан, Монгол Улсын Гавьяат тамирчин, Олон улсын хэмжээний мастер, дэд хурандаа Б.Цэвээндаш Цаст Гимлай Дэлхийн ноён оргилд

ганцаарчилсан "Соло" авиралт, хүчилтөрөгчгүй амь өрсөн аюултай буулт хийсэн билээ. Б.Цэвээндаш Монгол Улсынхаа Төрийн алтан соёмбот далбааг Эверестийн оргилд мандуулсан бахдам амжилтаараа 2016 оны

шилдэг тамирчнаар шалгарч, "Алтан хараацай"-н эзэн боллоо. "Алтан хараацай" шагнал нь спорт сонирхогч мастеруудын холбооны тэргүүн дээд шагнал юм. Спортын 11 төрлөөс 11 шилдэг тамирчин энэхүү шагналд нэр дэвшжээ.

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины I улирлын захиалга явагдаж байна

Захиалгын үнэ 22400₮

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025


"ХАД", "Монголын тэмүүлэл" багууд өнөөдөр аваргын төлөө тоглоно

Монголын Хөлбөмбөгийн Холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Футзалын эмэгтэйчүүдийн УАШТ"-ий медалийн төлөөх тоглолтууд өнөөдөр болох билээ. Өнгөрсөн лхагва гарагт хагас шигшээн хоёр тоглолт болж, финалд үлдэх багуудын нэр тодорсон юм. Хагас шигшээд "ХАД" болон "Арвис" клуб тулсан. Энэ тоглолтод "ХАД" өрсөлдөгчөө 3:2-оор буулгаж авч, аваргын төлөө шалгарч үлдсэн билээ. Тэгвэл нөгөө нэг тоглолт "Дэрэн" болон "Монголын тэмүүлэл" багийн хооронд болсон билээ. Хоёр баг үндсэн цагт 4:4-өөр тэнцэж, улмаар торгуулийн цохилт цохиход "Монголын тэмүүлэл" илүүрхлээ. Өнөөдөр хүрэл медалийн төлөө "Арвис", "Дэрэн" клубууд тоглох бол аваргын алтан цомыг "ХАД", "Монголын тэмүүлэл" клубууд булаалдана.

Мөсөнд авиралтын улсын аварга ирэх сард болно

Мөсөнд авиралтын 2016 оны улсын аварга шалгаруулах тэмцээн ирэх нэгдүгээр сарын 21, 22-нд товлгогджээ. Тэмцээн "Найрамдал" зусланд болох бөгөөд Монголын уулздын үндэсний холбоо зохион байгуулах юм байна. Хамгийн гол нь энэ жил анх удаа хиймэл мөсөн хана ашиглаж явуулах тул байгууламжийн барилгын ажлын явц, цаг агаарын нөхцөл байдал зэргээс шалтгаалж тэмцээнийг оны дараа хийхээр болжээ. Өмнөх жилүүдийн тэмцээнийг Өвөрхангай аймгийн Улаан Цутгалангийн хүрхрээнд зохион байгуулдаг байсан юм.

СПОРТ



Эзэн хааны цомд “ГООЛЫН БОРОО” орлоо

Н.ПУНЦАГ

Испанийн Лигийн цомын 1/16 шатны харну тоглолтууд болж байгаа билээ. Өнгөрсөн лхагва гарагийн шөнөөнэтэмцээнийхүрээнд зургаан тоглолт болж, шөвгийн 16-д үлдэх 12 багийн нэр тодорхой боллоо. “Реал Мадрид” клуб багийн ДАШТ оролцохоос шалтгаалаад аль эрт цомын тоглолтоо хийж, өрсөлдөгчөө бутниргэсэн. Тэгвэл мягмар гарагийн шөнө “Атлетико”

доод лигийн өрсөлдөгчөө хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 10:1-ээр буулгаж авч, шөвгийн 16 руу ороод байгаа. Харин лхагва гарагийн шөнө “Барселона” клуб талбайдаа “Эркулес” клубыг хүлээж авч, 7:0-ээр буулгаж авлаа. Ингэснээр хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 8:1-ээр хожиж, шөвгийн 16-д үлдэж байгаа юм. Тоглолтын 37 дахь минутад Динь тооны харьцааг нээсэн бол Ракитич 45, Рафинья 50 дахь минутад нэг нэгийг нэмжээ. Улмаар Арда Туран

55, 86, 89 дэх минутад хет-трик хийсэн бол дунд нь Пако Алькасер нэгийг оруулсан байна. Энэ тоглолтод Месси, Неймар, Суарес нар оролцоогүй ч “Барса” илт илүүрхэж чадлаа. Тэгвэл “Севилья” энэ шатанд “Форментера” клубыг талбайдаа хүлээж авч, харну тоглолтоо хийн, 9:1-ээр бутниргэлээ.

Өмнөх тоглолтод “Севилья” 5:1-ээр хожсон. Ингэснээр хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 14:2-оор бутниргэлээ. Тоглолтын 14 дэх

минутад Гансо тооны харьцааг нээсэн бол Вьетто 22, 43, 45 дахь минутад хет-трик хийсэн байна. Улмаар 24, 55, 88 дахь минутад Бен-Йеддер хет-трик хийж, Сарабия, 27, 77 дахь минутад дубльджээ. Одоогоор “Барселона”, “Реал Мадрид”, “Атлетико Мадрид”, “Севилья”, “Эйбар”, “Валенсия”, “Осасуна”, “Департиво”, “Вильярреал”, “Реал Сосьедад”, “Лас-Пальмас”, “Кордоба” гэсэн 12 баг шөвгийн 16-д үлдээд байна. Өнгөрсөн шөнө

үлдсэн багуудын нэр тодорсон байх ёстой. Ингэснээр шилдэг 16 баг тэмцээнээ цааш үргэлжлүүлэх нь. Хамгийн сонирхолтой нь Лигийн цомын энэ шатанд маш олон гоол орлоо. “Реал” өрсөлдөгчөө хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 14:2-оор хожсон. Тэгвэл “Барселона” 8:1-ээр, “Атлетико” 10:1-ээр, “Севилья” 14:2-оор бутниргэсэн. Ердөө л Ла лигийн эхний байруудад бичигдэж байгаа багууд хоёр тоглолтод 46 гоолыг оруулж амжсан юм.

“Манчестер Юнайтед” Гризманин, Линделлеф, Семеду, Бакайоко нарын төлөө 180 саяыг өгнө

Английн алдарт “Манчестер Юнайтед” клуб ирэх өвөл болон дараа жилийн зуны солилцоо наймааны төлөвлөгөөгөө гаргаад байгаа ажээ. The Telegraph-ийн мэдээлж байгаагаар өвлийн солилцооны цонхоор Манчестер хотын баг Португалын

“Бенфика” клубын хамгаалагч Виктор Линделлефыг 38 саяар авахаар төлөвлөжээ. Харин зуны солилцооны цонхоор “Атлетико” клубын довтлогч Антуан Гризманин, “Монако”-гийн хагас хамгаалагч Темуэ Бакайоко, “Бенфика”-гийн хагас

хамгаалагч Нелсона Семеду нарыг авахаар төлөвлөж байгаа юм байна. Гризманыг 84 саяар үнэлж байгаа бол Семеду 25, Бакайоког 35 саяар авахаар төлөвлөжээ. Ингэснээр энэ дөрвөн тоглогчид нийт 180 саяыг зарцуулах аж.

“Шапекоэнсе” багт Судамерикана-2016 тэмцээний цомыг гардууллаа

Өмнөд Америкийн хөлбөмбөгийн холбооноос Бразилын “Шапекоэнсе” багт Судамерикана-2016 тэмцээний цомыг гардуулж өглөө. Тус багийн тоглогчид энэхүү тэмцээнд оролцохоор Колумб руу нисч явахдаа онгоцны осолд орж, нас барцаасан билээ. Энэхүү эмгэнэлт үйл явдлын дараа “Шапекоэнсе” багийг ялагчаар тодруулсан юм. Онгоцны ослоор 71 хүн амь насаа алдсаны дотор тус багийн 19 тоглогч байсан билээ. “Шапекоэнсе” клуб энэхүү тэмцээний финалд “Атлетико Насьональ” клубтай тоглох ёстой байсан юм. Харин Колумбын баг энэхүү тэмцээний цомыг Бразилын клубт өгөхийг хүссэн. Ингэснээр Өмнөд Америкийн хөлбөмбөгийн холбоо тэдэнд цомыг нь гардууллаа. Түүнээс гадна цомыг дагалдуулан сая ам.долларын шагнал өгчээ.



“Байерн” нэгдүгээр сард Роббены гэрээг сунгана



Германы алдарт “Байерн Мюнхэн” клубын ТУЗ-ийн дарга Карл-Хайнц Румменигге багийн хагас хамгаалагч Арьен Роббены гэрээг сунгах гэж байгаа талаар ярьжээ. Тэрбээр “Бид нэгдүгээр сард түүнтэй шинэ гэрээ байгуулах тал дээр ярилцана. Би энэ асуудлыг өөдрөөр харж байгаа. Хоёр тал хоёулаа гэрээгээ сунгахыг хүсэж байгаа юм” хэмээн ярьжээ. Өдгөө 32 настай Голланд эрийн гэрээ 2017 онд дуусах учиртай. Роббен 2009 оноос Бундес лигт тоглож байгаа бөгөөд энэ улиралд 10 тоглолтод оролцож, таван гоол оруулж, дөрвөн оновчтой дамжуулалт өгчихөөд байна.

“Интер” Феллайниг авахыг хүсч байна

Италийн алдарт “Интер” клуб Английн “Манчестер Юнайтед”-ын хагас хамгаалагч Маруан Феллайниг сонирхож байгаа ажээ. Милан хотын баг өдгөө 29 настай Бельги эрд санал тавихаар бэлтгэж байгаа юм байна. Харин “Манчестер Юнайтед”-ын дасгалжуулагч Жозе Моуриньо түүнийг олон байрлалд тоглох чадварыг нь үнэлж, нэгдүгээр сард зарахыг хүсэхгүй байгаа аж. Феллайнигийн хувьд нөхцөл байдлыг тайван ажиглаж байгаад бөгөөд ирэх зун гэрээгээ сунгах боломжийг хайж буй гэнэ. “Интер”-ээс гадна “Милан” ч гэсэн түүнийг бас сонирхож эхэлсэн байна. “Манчестер Юнайтед”-ын хувьд 20 саяыг өгсөн багт Феллайниг зарах хүсэлтэй байгаа талаар өмнө нь мэдээлэл гарч байсан билээ.

“Барса” хүссэн цалинг нь өгөхгүй бол Месси Хятад руу явна

Испанийн алдарт “Барселона” клубын довтлогч Лионель Месси Хятад руу явж магадгүй талаар зарим эх сурвалжууд мэдээлж эхэллээ. Аргентин эрийн найз болох хөлбөмбөгч хэрвээ Каталаны баг шинэ гэрээ санал болгохдоо түүний цалингийн шаардлагыг биелүүлэхгүй бол Хятад руу явна хэмээн ярьсан гэж Estudio Estadio мэдээлжээ. Харин El Mundo Deportivo-гийн мэдээлснээр Месси Хятад руу явна гэж ярьсан найз нь “Челси”-гийн хагас хамгаалагч Сеск Фабрегас гэнэ. Хятадын “Хэбэй Чайна Форчун” баг Мессид жилд 100 сая еврогийн цалин өгөхөөр амалж, авахыг оролдож байгаа талаар мэдээлэл гарсан. Харин “Барселона”-гийн зүгээс түүнтэй 2017 оны эхний улиралд багтааж гэрээгээ шинэчлэхээр найдаж байгаа талаар мэдээлэл байгаа билээ.



СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭН

Мацүмото Каори: Д.СУМЪЯАГ ХЭТ БАРДСАНААС БОЛЖ ЯЛАГДСАН



Төгсгөл.
Түрүүч нь V нүүрт

-Каори Мацүмото багаасаа жүдоогоор хичээллэж эхэлсэн. Дөнгөж спортод хөл тавьж байсан тэр үеэ эргээд дурсаач?

Миний ах эхлээд жүдоогоор хичээллэж эхэлсэн юм. Тэгээд л ахынхаа нөлөөгөөр зургаан нас хүрэхийн өмнөхөн Ивай жүдогийн сургуульд явж эхэлсэн. Тухайн үед ээжийн "чихэр өгнө шүү" гэх үгэнд нь хууртагдаж, жүдогийнхоо дэвжээ рүү явж байсан үе ч бий. Бэлтгэлийн дэвжээ тун ч хатуу. Эхэндээ хагас жил орчим хугацаанд долоо хоногтоо ганц удаа зүгээр л барилдааны бэлтгэл хийдэг байсан. Ер нь миний өнөөгийн арга барилд тухайн үеийн бэлтгэл нөлөөлсөн юм болов уу гэж боддог юм. Бэлтгэл сургуулилт хийсний ачаар мэх маань ч гэсэн бага багаар сайжирч байлаа.

-Ахлах сургуулийн сурагч болохдоо ч жүдогийн бэлтгэлээ үргэлжлүүлсээр байсан уу?

Фүжимурагийн охидын ахлах сургуульд орох үедээ "Mitsui Sumitomo"-гийн талбайг түрээсэлж, бэлтгэлээ хийж эхэлсэн. Гэхдээ надад тэндэхийн жүдогийн арга барил нэг л наалдаж өгөхгүй байгаа юм шиг санагдаад ахлах сургуулийн хоёрдугаар ангид орох жилээ Каназава сургуульд элсэж, тэндээсээ Тэйкёо их сургуульд дэвшин суралцсан юм. Харин 2008 онд Бээжингийн Олимпын жүдогийн баг тамирчны бэлтгэл хангагчаар сонгогдож, тэр үеэс эхлэн олон улсын чанартай Жүдо бөхийн тэмцээн уралдаанд оролцож эхэлсэн дээ. Тэр үед хэдний бэлтгэл хангагчаар оролцсон ч, том тэмцээнд орох анхны алхмаа хийчихлээ гэж бодож, 2012 оны олимпод өөрөө оролцох том зорилго тавьж билээ.

-Лондонгийн олимпоос алтан медаль авсныхаа дараа та авыгаа халшрах синдромтой гэдгийг нь мэдсэн гэсэн?

Лондонгийн олимпод оролцож, алтан медаль авах зорилгоо биелүүлсний дараа халшрах синдром туссан мэт л сэтгэл ханаж билээ. Тэгээд л бараг нэг жил орчим амралтын байдалтай байсан. Бэлтгэл хийж байсан ч, төдийлөн идэвхи гаргалгүй зүгээр л цагаа жүдод зориулан өнгөрүүлдэг байлаа. Жил орчим амарсны эцэст 2016 оны Риогийн олимпод жинхэнэ утгаар нь бэлтгэж эхэлсэн ч, сэтгэлд том хар нүх үүсэх мэт нөхцөл байдалтай тулгарсан. Нэг удаа би хүний сэтгэцийн өвчлөлтэй холбоотой номыг сонирхож уншсан юм. Гэтэл түүнээс авыгаа олж хараад, санаа зовниж эхэлсэн. "Хүн гэж юу вэ, Хүн яагаад өвчилдөг вэ" гэх гарчигтай номууд ширээн дээр өрөөстэй байгааг хараад аав минь харин намайг ямар нэг сэтгэцийн

өвчин туссан юм байх даа гэж бодсон гэсэн. Тэр үед аав "Намайг Рио де Жанейрогийн олимпод дагуулаад яваач" гэж хэлж билээ. Надад аваас өөр сэтгэл зовниж асуудал байгаагүй ч, "аав намайг дэмжих гэж байгаа юм болов уу" л гэж бодож билээ. Аавын тэр үг Риогийн олимпод оролцох зорилгыг минь улам хурцалж өгсөн.

-Аавыгаа сэтгэцийн өвчтэй гэдгийг мэдсэн гэлээ. Тэгээд Рио де Жанейрогийн наадамд оролцох хүртэл таны сэтгэлгүйн байдал ямаршуу байв даа?

2016 оны дөрөвдүгээр сард болсон Японы жүдо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд ялагдсан. Гэсэн ч, Риогийн олимпод оролцох эрхээ авсан юм. Тэмцээнд ялагдсан нь миний алдаа гэж бодон гэмшиж бас харамсч байсан ч, Риогийн олимпод багаа доош таталгүй заавал медаль авах

Тэр үед тайван барилдаж байгаад л ялчихсан. Харин дараа нь Францын Отон Павьтайг таарсан. Бид олон жил таарч байсан учраас "Энэ удаа ч гэсэн ялна" гэж бодож байсан юм. Тэгээд эхэндээ онооны давамгайл байдлаар ялахаар төлөвлөсөн ч, тактикаа өөрчилсний эцэст ялсан.

-Медалийн төлөөх шийдвэрлэх барилдаанд ялагдсан шүү дээ. Энэ талаар ямар бодолтой байна вэ?

Том уул гэж төсөөлж байсан хэсгийн аваргын барилдаанаас гарсны дараа хагас шигшээд тун хайхрамжгүй барилдсан гэж одоо боддог. Монголын жүдоч Д.Сумьяатай хийсэн барилдаанд яагдах үед ч, "Сул өрсөлдөгч таарлаа" гээд бодчихсон байсан. Ер нь олимпод оролцохдоо тэмцээн дуусах хүртэл өрсөлдөгчөө бардаж болдоггүй. Нэг удаа л "сул өрсөлдөгч" гээд бодчихвол мэх хийх, хариу үйлдэл үзүүлэх чадваргүй болчихдог юм. Хэт бардсан маань л миний ялагдлын шалтгаан болсон юм уу даа.

-Тэр ялагдлаас та юу сурав гэдэг одоо хамгийн чухал болов уу?

Риогийн олимпын хүрэл медалийн төлөө Тайванийн бөх Лин Чен Линтэй барилдаж ялсан. Ний нуугүй хэлэхэд, тэмцээн дуусах мөчид "за дууслаа" л гэж бодсоноос биш хүрэл медаль авсанд баярлаагүй. "Яагаад хагас шигшээд тийм хайнга байдал гаргачихав" гэдэгтээ л харамсч байлаа. Энэ гэмшил одоо ч өөрчлөгдөөгүй. Хэрвээ би Риод одтой байж, алтан медаль хүртсэн бол зүгээр л баярлаж, цаашдын жүдогийн арга барилынхаа талаар гүн гүнзгий бодол тээхгүй байсан байх. Бодож санах зүйлгүй, хэн юу гэж бодож буйг ч анзаарахгүй "Би бүхнийг зөв хийсэн учраас л медаль хүртсэн" гэж бодох байлаа. Спортын ертөнцөд ялагч өөрийнхөө үйлдэл бүрийг зөвтгөдөг. Лондонгийн олимпын дараа Риогийн олимпод бэлтгэж байхдаа ч би хүмүүсийн надад хэлж буй үг, шүүмжийг төдийлөн сонсдоггүй байсан юм шиг санагддаг. Харин тэр ялагдлын дараа ингэж бодоход хүрсэн. Хувь хүн талаасаа сайн сургаж болсон байж магадгүй.

-Дараагийн олимп Токиод болно шүү дээ. Энэ талаар?

2020 оны Токиогийн олимп хөгжөөн дэмжигчдийн яг дэргэд болно. Энэ утгаараа онцгой боломж учраас мэдээж, оролцохыг хүсч байна. Риогийн олимпын үзсэн хүмүүс "Мацүмотогийн барилдахыг хараад урам зориг орсон", "Энэ барилдаан амаргүй байсан ч, ахиад жаахан хичээх хэрэгтэй гэж бодлоо" гэсэн үгсийг надад хэлж байсан. Тэр үед зөвхөн өөрийнхөө төлөө барилддаг жүдо түмний төлөөх жүдоогоор солигдсон мэт санагдаж, үнэхээр их баярлаж билээ.

...Монголын жүдоч Д.Сумьяатай хийсэн барилдаанд яагдах үед ч, "Сул өрсөлдөгч таарлаа" гээд бодчихсон байсан. Ер нь олимпод оролцохдоо тэмцээн дуусах хүртэл өрсөлдөгчөө бардаж болдоггүй. Нэг удаа л "сул өрсөлдөгч" гээд бодчихвол мэх хийх, хариу үйлдэл үзүүлэх чадваргүй болчихдог юм...

ёстой гэж бодсон. Лондонгийн олимпод оролцох үедээ би зөвхөн өмнөхөө харж, тэмцээнээсээ өөр юу ч бодож, сатаарч байгаагүй. Тийм учраас энэ мэт туршлагадаа үндэслэн Рио де Жанейрогийн олимп хүртэл маш тайвнаар "Тэмцээний өдөр хүртэл юу хийх ёстой вэ" гэдгээ тунгаах хэрэгтэй байлаа. Гэтэл Риогийн олимпын өмнөхөн болсон "World Masters" тэмцээнд ялагдсан ч, олимп хүртэл бэлтгэл сургуулилтаа шинэчлэх хугацаа байсан учраас төдийлөн сандраагүй.

-Риогийн эхний барилдууны талаар яриач?

Рио де Жанейрогийн олимпын үеэр хагас шигшээд өвдөг шороодох хүртэл ямар ч саад надад байхгүй мэт санагдаж байлаа. Ингэхдээ хамгийн эхний барилдааныг Зааны ясан эрэг улсын Зулехиа Абзетгатай хийсэн.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Э.Бэхбаяр Энэтхэгийн "Pro wrestling league season 2" тэмцээнд уригджээ



Энэтхэг улсад 2017 оны нэгдүгээр сарын 2-ны өдрөөс эхлэх "Pro Wrestling League season 2", "Мэргэжлийн бөхийн лиг"-ийн хоёрдугаар тэмцээнд манай бөхчүүдээс Гавьяат тамирчин Э.Бэхбаяр уригджээ. WWW, Дэлхийн бөхийн нэгдсэн холбоо, Энэтхэгийн бөхийн холбоо хамтран зохион байгуулж байгаа тус тэмцээнд манай улсаас найман эрэгтэй, зургаан эмэгтэй бөхийн нэрийг явуулсан байжээ. Тэр дундаас Э.Бэхбаярыг л урьсан юм байна. Тус тэмцээнд зохион байгуулагч орны Дели, Пенджаб, Жайпур, Уттар Прадеш, Мумбай, Харьяна гэсэн зургаан хотын баг оролцох юм байна. Дели хотын багт Э.Бэхбаярын хамт энэтхэгийн бөх Пуни Бажранг, Сагаяарт Каднан, Олимпын хүрэл медальт Сакши Малик, Погат Сандепа, Азербайжаны бөх, олимпын мөнгө, хүрэл медальт, дэлхийн аварга Мария Стадник нарын шилдэг бөхчүүд багтаж байгаа аж. 2015 онд болсон "Pro Wrestling League season 1" тэмцээнд манай улсаас Гавьяат тамирчин Г.Мандахнаран, П.Өнөрбат, олон улсын хэмжээний мастер Ж.Чулуунбат нар уригдан оролцож байсан юм.

Г.Отгонцэцэг 22, М.Уранцэцэг 13.5 мянган ам.долларын урамшуулал авчээ

Олон улсын жүдо бөхийн холбооноос энэ онд хамгийн их шагнал, урамшуулал хүртсэн жүдочийн нэрсийг зарлажээ. Энэ жагсаалтыг Казахстаны нэр дээр барилдаж байгаа монгол тамирчин Г.Отгонцэцэг тэргүүлжээ. Түүний араас Шведийн Маркус Ньюман, Нидерландын Гуус Стенхунс нар жагссан байна. Г.Отгонцэцэг энэ онд жүдогийн цуврал тэмцээнд дөрвөн удаа түрүүлж, хүртсэн медалийн тоогоороо бусад тамирчдаа тэргүүлжээ. Түүний шагналын мөнгөн дүн 22 мянган ам.долларт хүрсэн байна. Манай улсаас дэлхийн аварга, "Рио 2016" олимпын наадмын V байрыншагналт М.Уранцэцэг 13.500 ам.долларын урамшуулал авч, уг жагсаалтын 14 дүгээрт бичигджээ.



Тал нутгийн цахим мэдээлэл



СПОРТ

“Бөртэ чоно”-ын эзэг өнөөдөр тодорно



Н.БОЛД

...Хамгийн өндөр боломжтой нь Д.Отгондалай. Боскын спортын түүхэнд гарч ирсэн шилдэг тамирчдын нэг. Медалийн буухиаг ямар ч байсан таслаагүй, Олимпын хүрэл медаль авсан. Бас л шүүлтийн асуудлаас болоод медалийн өнгөө хувиргах боломжоо алдчихсан...

Үеэр шилдгийн шилдгүүдийг зарлана. Спортын сэтгүүлчдийн оролцох санал хураалтын шугам арванхоёрдугаар сарын 16-ны 00:00 цагт нээгдэж, өчигдөр орой 23:59 цагт хаагдлаа.

Оны шилдэг эмэгтэй тамирчин номинацид МУТГ, Олимпын мөнгөнмедальт Д.Сумьяа, дэлхийн аварга, Токиогийн “Их дуулга” тэмцээний аварга М.Уранцэцэг, Гавьяат тамирчин О.Гүндэгмаа,

хүндийн өргөлтийн М.Анхцэцэг тэргүүтэй 10 шилдэг тамирчин нэр дэвшин өрсөлдсөн. Өнөөдөр нэг нь шилдэг болно. Шилдэг болох хамгийн өндөр магадлалтай тамирчин бол Д.Сумьяа. Тэрбээр Рио-гийн Олимпын наадмаас мөнгөн медаль хүртэж, эх орныхоо нэрийг дуурсгасан. Эзэн орны бөхтэй учраа таарч, бага сага шүүлтийн асуудал ороогүй бол түрүүлэх байлаа. Мөн тэрбээр энэ онд хамгийн өндөр амжилт үзүүлсэн тамирчин шүү дээ. Тийм болохоор шилдэг эмэгтэй тамирчин болох нь дамжиггүй биз ээ. Харин шилдэг эрэгтэй тамирчны төлөө Олимпын хүрэл медальт Д.Отгондалай, чөлөөтийн шилдэг тамирчин Г.Мандахнаран, Паралимпийн хүрэл медальт Э.Содномпэлжээ, Б.Ууганхүү зэрэг есөн тамирчин өрсөлдсөн. Өнөөдөр мөн л нэг нь шилдгээр тодрох учиртай.

Хамгийн өндөр боломжтой нь Д.Отгондалай. Боскын спортын түүхэнд гарч ирсэн шилдэг тамирчдын нэг. Медалийн буухиаг ямар ч байсан таслаагүй, Олимпын хүрэл медаль авсан. Бас л шүүлтийн асуудлаас болоод медалийн өнгөө хувиргах боломжоо алдчихсан. Түүнтэй ойртож очих өндөр амжилт гаргасан эрэгтэй тамирчин

байхгүй. Хэрвээ Г.Мандахнаран хүрэл медаль авчихсан байсан бол энэ хоёрын хооронд өрсөлдөөн өрнөх байлаа. Гэвч авч чадаагүй. Паралимпийн хоёрын хувьд медаль хүртсэн. Гэхдээ л Д.Отгондалайгаас илүү санал авч чадахгүй болов уу. Оны шилдэг залуу тамирчны төлөө Б.Сумьяа, Б.Тэгшбаяр, Э.Тэмүүжин нар өрсөлдсөн. Б.Сумьяагийн хувьд Олимпын аварга болж чадсан. Өвлийн спортын түүхэнд байгаагүй гайхалтай амжилт. Тэр утгаараа шилдэг болох болов уу. Оны шилдэг багийн төлөө сагсан бөмбөгийнхөн голлуу өрсөлдсөн. Сагсан бөмбөгийн оюутны 3x3 тэмцээний дэлхийн аваргын мөнгөн медаль авсан багт илүү боломж байгаа байх. Бусад нь бол тивийн болоод улсын тэмцээнд түрүүлсэн багууд байгаа.

Шилдэг дасгалжуулагчийн төлөө Ч.Базарсүрэн, Д.Батсүрэн, Х.Эрдэнэт-Од, Ё.Төмөрбатаа, Ц.Цогтбаяр зэрэг есөн дасгалжуулагч өрсөлдсөн. Д.Сумьяагийн амжилтад хүрэх замыг засч, Олимпын дэвжээнд авч гарч байсан Х.Эрдэнэт-Од гавьяат шилдэг болох боломжтой. Түүнтэй боксын хоёр дасгалжуулагч болох Д.Батсүрэн, Ё.Төмөрбатаа нар хүчтэй өрсөлдөх болов уу.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -11
Шөнө -21

Нөгөөдөр
Өдөр -19
Шөнө -25

Өдрийн зурхай

Өвлийн дунд цагаан хулгана сар нэг цагаан мэнгэтэй шарагчин туулай өдөр

Наран ургах шингэх: 08.40-17.03
Үс засуулбал: Нүд бүрэлзэн улцайна



Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналттай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр эл засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг даргахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хуучас олдох, баруун нүд татвал тэлцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрлөс татвал үг, асуулт болох болой. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.

Томас Бах мэндчилгээ илгээжээ

Олон улсын олимпын хорооны ерөнхийлөгч Томас Бах Монголын Үндэсний Олимпын хорооны 60 жилийн ойг тохиолдуулан мэндчилгээ илгээсэн байна. Тэрбээр “Монголын үндэсний олимпын хороо 60 жилийн түүхийг бичсэн нь спорт, олимпын

хөдөлгөөний онцгой үйл явдал” болохыг тэмдэглэжээ. Түүний мэндчилгээнд Монголын үндэсний олимпын хороо /МҮОХ/-г олимпын хөдөлгөөний идэвхтэй, найдвартай түншийн зиндаанд хүрснийг онцолсон байжээ. МҮОХ-г 1956 оны хоёрдугаар сарын

6-ны өдөр МАХН-ын төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн хамтарсан тогтоолоор байгуулж байжээ. 60 жилийн хугацаанд Монгол Улс өвөл, зуны 26 олимпын наадамд тамирчдаа оролцуулж, хоёр алт, найман мөнгө, 16 хүрэл медаль хүртжээ.

Спортын эрдэм шинжилгээний бага хурал боллоо



МҮОХ-ны 60 жилийн ойд зориулсан спортын эрдэм шинжилгээний бага хурал өчигдөр боллоо. Тус хуралд олимпын хорооны салбар зөвлөл, спорт холбоодын төлөөлөл, их дээд сургуулийн багш, судлаач нар оролцсон юм. Төрөлжсөн сургалттай биеийн тамир, спорт дунд сургуулийн захирал, доктор, профессор Ч.Зоригтбаатар “Хүүхдийн спорт-өнөө ба ирээдүй” сэдвээр илтгэлдээ спортын чиглэлээр улсын хэмжээнд найман сургууль байгааг хэллээ.

Нийтдээ 2259 сурагч, 337 багш ажиллаж байгаа юм байна. Цаашид Биеийн тамир, спортын тухай хуулинд өсвөрийн тамирчдыг бэлтгэх, дэмжих, хөгжүүлэх талаар шинэчилсэн хувилбар боловсруулах, дунд сургуулийн цогцолборыг 2017-2018 онд барьж ашиглалтад оруулах, аймаг дүүрэг тус бүрт спортын төрөлжсөн сургууль байгуулах шаардлагатай гэв. МВХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Бат-Энх “Спорт холбоод бие даасан салбар болон хөгжих,

салбарын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хүний нөөцийн бодлого, шинэ мэргэжил хандлага хэрэгтэй”-г илтгэлдээ онцлон ярих. Ялангуяа эрх зүйч, эдийн засагч, маркетер, хоол судлаач, сэтгэл зүйч, агент буюу зуучлагч, спортын менежмент, дасгалжуулагч-шүүгч-тамирчны лицензийн асуудал гээд спорт холбоод энэ чиглэлд боловсон хүчнээ бэлтгэх шинэ төвшинд гарч ажиллах хэрэгтэйг хэлж байлаа.

ТЭНГИС

РЭКЕТ

FANTASTIC BEASTS

Харри Поттер сургууль дээрээ нэгэн зохиол унших болно. Харин тэр зохиол нь 70 жилийн өмнөх шидэтнүүдийн талаар болон Нью Йорк хот дахь нууц бүлгэмийн Newt Scamander-ийн адал явдал өгүүлэгдэх болно.

Соко, Халиуна, Хулан, Тамираа, Анар нар 23-24 насны охидууд. Тэд огт санаандгүй байдлаар харанхуй хонгилд сэрэх болно. Хаана байгаага ч мэдэхгүй, гэнэн цайлган таван охины санаанд оромгүй, авралд хүрэх гэсэн хөгжилтэй аргууд нь аюул дагуулж байгааг хэн нь ч ухаарсангүй. Гэвч тэд бэрхшээлтэй асуудлынхаа өмнө сөрөн зогсож чадах болов уу...? Үйл явдал цааш үргэлжлэх тусам инээдэм адал явдлаар дүүрэн, таныг хэзээ ч уйдаахгүйг амлаж байна.

Шинэ жилийн орой ажлынхантайгаа архи ууж, дараа нь согтуугаар машин барьж явсан Ганзориг, өвөө эмээгийнхэрээ орж бэлэг аваад харьж явсан аав, охин хоёрыг дайрч алаад хэргийн газраас зугтсанаар хүйтэн өвлийн энэхүү тууж эхэлнэ.

100,000т БАЛГАХ КАРТ
50,000т БАЛГАХ КАРТ
30,000т БАЛГАХ КАРТ
НОГ ХЭДЭА ҮЗЭХ БАЛГАХ КАРТ КЛУБ
ХОСЫН КАРТ 15,000

УЛААНБААТАРТ

PASSENGERS
LA LA LAND
АЛААРЫН ЭЗЭМ
ASSASSIN'S CREED

SODON cleaning service

БҮХ ТӨРЛИЙН ЦОГИ ЦЭВЭРЛЭГЭЭ

АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Их цэвэрлэгээ
- Гэрээт цэвэрлэгээ
- Гадна фрасадны цэвэрлэгээ
- Гадна талбайн цэвэрлэгээ
- Барилгын болон засварын дараах цэвэрлэгээ
- Үдэшлэг үйлээн авалтын дараах цэвэрлэгээ

АЙЛ ӨРЖИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Их цэвэрлэгээ
- Энгийн цэвэрлэгээ
- Хэсэгчилсэн цэвэрлэгээ
- Цонк тагтны цэвэрлэгээ
- Цонк тагтны засвар үйлчилгээ
- Нивс, нивсэнцэр цэвэрлэгээ

УТАС: 95018180, 88120500, 99003618
FACEBOOK: SODON SERVICE